

Орон бүхний пролетарийн нар нэгдэгтүн!

АНХ ДУГААР

ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 61 (2368)

1974 оны 8 дугаар сарын 29

ПҮРЭВ

СОЦИАЛИСТ УРАЛДААН

НӨӨЦ БОЛОЛЦОО

Аймгийн хэмжээгээр энэ оны социалист уралдаанд төлөвлөгөөнөөс 3 сая гаруй төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэж, ашгийг 1,5 сая, орлогыг 1,3 саяар, малыг 39,0 мянган толгойгоор давуулах үүрэг аваад эхний хагас жилийн байдлаар амжилттай биелэгдлээ.

Угтаал, Баян-Өнжүүл, Баянцагаан, Батсүмбэр сум-хороод, Хүнсний үйлдвэр, Холбооны газар, Хэвлэх үйлдвэр зэрэг газруудын нам, захиргаа, ҮЭ-ийн байгууллагууд ажлын явц үр дүнг ажилчин, үйлдвэрийн салбар-бүрт нарийвчлан тооцож дүгнэж амжилтанд хүрч байна.

Социалист уралдааны амлалт үүргийг ажилчин хамт олны өөрсдийн нь үүсгэл санаачлагын үүднээс өрнүүлж чадвал сая төлөвлөгөөт зорилтыг давуулан биелүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, өөрийн өртгийг хямдруулан материал хөдөлмөр мөнгөн санхүүг арвинлан хэмнэж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулан, эдийн засгийн гол зангилаа асуудлыг амжилттай шийдвэрлэж болдгийг манай үйлдвэр, ХАА-н тэргүүний байгууллагуудын туршлага харуулж байна.

Гэгч социалист уралдааны үүргийн нийгэм-эдийн засгийн ач холбогдлыг газар бүр ажилчин нэг бүрт зохих ёсоор бүрэн ойлгуулж чадаагүй, уг асуудалд ёс төдий хандлагаас үйлдвэрийн төлөвлөгөө тасрах, уралдаанд авсан үүргээ бүрэн биелүүлэхгүй байна.

НААҮ-ний газар, Ойн үйлдвэр, Усны аж ахуйг удирдах газрууд нэр төрлийн төлөвлөгөөг, НААҮ-ний газрын үйлдвэрийн ажилчдын 40 гаруй хувь нь эхний хагас жилийн төлөвлөгөөг, Усны аж ахуйг удирдах газар эхний хагас жилийн төлөвлөгөөг 500,0 мянган төгрөгөөр тасалдуулж 331,0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Аймгийн Барилга угсралтын контор, НААҮ-ний газар, Ойн үйлдвэрт эхний хагас жилд ажлын цагийн нягтрал сул, дотоод нөөц бололцоогоо дайчлан ашиглаж чадаагүйгээс жинхэнэ бүтээлч дагаас 1,0—8,0 мянган хүн цагийн ажил таслалт сул зогсолт гарчээ.

Дээрхи гарздалын 80,0 хувийг ашигдаж чадсан бол дунджаар 204,9 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоо байжээ.

Энэ бол өөрт байгаа бололцоог алдаж социалист уралдааны үүргийг нарийн судалгааны үндсэн дээр эдийн засгийн шахуу тооцоогүй боловсруулж ажилчин, хамт олноос амлалт үүрэгтээ эзэн ёсоор хандан ажиллах тэмцлийг хангалтгүй зохион байгуулснаас болжээ.

Нөгөө талаар ажилчин, хөдөлмөрийн хамт олны уралдаанд авсан үүргийг биелүүлэхэд нь үйлдвэр, ХАА-н байгууллагын захиргаа, тэдгээрийг дэргэдэх нам, ҮЭ-ийн байгууллагаас удирдан туслах, зохион байгуулах, сурталчлах ажлын эрч далайц хангалтгүй байна.

Иймд үйлдвэр, ХАА-н газруудын үйл ажиллагаанд улирал тутам үзлэг явуулж, нөөцийг илрүүлэн түүнээ тухай бүр уралдааны үүрэгт нэмэлт болгон авахуулж байвал зохино.

Үйлдвэрлэлийн нэгж ажилчдын хоорондын уралдааныг чанаржуулах, дүгнэх ажилд байгууллага бүр ажлын онцлогтой тохирсон аргачлалтай болох нь чухал юм. Бүх ард түмний социалист уралдааны жил 1974 оны 2 дугаар хагасын төлөвлөгөөт зорилтыг МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн наана бүх үзүүлэлтээр жигд биелүүлэхийн тулд уралдааныг улам эрчимтэй зохион байгуулан, хөдөлмөр материал, санхүүгийн бүхий л нөөц бололцоог илрүүлэн ашиглахад бүх нийтийн хүчийг чиглүүлэе.

ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ БИЕЛҮҮЛЭВ

Батсүмбэрийн сангийн аж ахуй энэ жилийн хадлан тэжээл бэлтгэх ажилд механикжсан I, морин машины 8 бригадыг 6700 тонн өвс хадах төлөвлөгөөтэй зохион байгуулан гаргажээ. Эдгээр бригадын дотроос Жадамба даргатай хадлангийн бригад энэ жил 700 тонн өвс хадах төлөвлөгөөтэй ажиллаж 8

сарын 20-ны байдлаар 733 тонн өвс хадаж төлөвлөгөөг 104,4 хувь биелүүлж сайхан амжилт гаргалаа.

Тус бригадын хадланч Нямдорж, тармагч Цэвээн, бухалдагч Ц. Батмөнх, Гавьяа, А. Бүдрэгч нар өдрийнхөө төлөвлөгөөг 101—110 хувиар биелүүлэн бусдыгаа хошуучлан ажиллав.

Тариалангийн талбайд

УРГАЦ ХУРААЛТ ЭХЭЛЛЭЭ

Тус аймаг улсын хэмжээгээр хураан авах үр тарианы 26 хувь, төмсний 43,2 хувь, хүнсний ногооны 56,7 хувь, тэжээлийн ургамлын 35,1 хувийг нийлүүлэж.

Иймээс ургац хураалт дээр дотоод нөөц бололцоог дайчлан ажиллах хүч, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн ажлын хариуцлага сахилга багцыг өндөржүүлж ажлын цагийн ашиглалтыг сайжруулан намын үзэл суртлын ажлыг ургацын талбарт төвлөрүүлэн ажиллах явдал чухлаар шаардагдаж байна.

Аймгийн хэмжээгээр ургац хураалтад 440 комбайн, ангиалангийн жатка 391, үр цэвэрлэгээний олон зуун машин ажиллахад бэлэн болоод байна. Энэ жилийн ургац хураалтад үр тариан, төмс, хүнсний ногооны 11 тасга, 59 бригад, 122 сая, 31 үтрэм зохион байгуулагдан ажилдаа орлоо.

Намын тариа ногоо, төмс хураалтад 4400 оюутан сурагчид, 1230 гаруй автомашин түүнд шаардагдах аж ахуй, ахуй үйлчилгээний бэлтгэл орон сууц, хоол хүнснийг бэлтгэв.

САА, ТАА, нэгдлүүд өдөрт 8000-аас 9000 га газрын ургацыг ангиалан, 7000—8000 га газрын ургацыг цайруулан ангиалан

тыг ажлын 7—10 хоногт, цайруулалтыг 15—18 хоногт, төмс хүнсний ногоог 10—15 хоногт багтаан хураах тооцоо төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тус аймгийн САА, ТАА-д ЗХУ-аас тэргүүний туршлагатай 60 гаруй комбайнчид ирж туслаж байгаагийн дээр комбайн, хадагч машин нэг бүрийг ээлжийн жолоочтой болгож, ажиллах цагийг нэмэгдүүлжээ. Тарианы иш богино, ургац шингэн учир ургац хураахад шаардагдах техникийн арга технологийг нарийн эзэмшиж ургацыг хаягдалгүй хурааж авах явдал чухал байна.

Ургац хураалтын талаар МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэн ургац хураалтын шат дамжлага бүрийг жигд тасралтгүй ажиллахаар зохион байгуулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж хөдөлмөр хамгааллыг сайжруулан хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн улсын төлөвлөгөөг биелүүлэхэд социалист уралдааныг өрнүүлэн мэдээ мэдээллийг шуурхай болгох нь чухал байна.

Жаргалантын САА энэ жил 32976 га газраас үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ур-

гамал хураах ажлаа бэлтгэл зохион байгуулалт сайтай эхэллээ. Тус сангийн аж ахуйнхан МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой угтаж 45 хоногийн өндөрт бүтээлийн ажил зохиож 24000 га газрын үр тариан ажлын 10 хоногт ангиалан хадахаар 121 комбайн гарч өдөрт 3000-аас 3600 га газрын ургацыг ангиалан хадаж, цайруулалтыг ажлын 12 хоногт дуусгах зорилт дэвшүүлэн ургацын штабыг Зардал тасгийн төвд төвлөрүүлэн ажиллаж байна.

Ургац хураалтын ажилд туслахаар МУИС-ийн 200 оюутан, Хөнгөн хүнсний үйлдвэрийн яамны харъяа авто тээврийн баазын тээвэрчид тус САА-д ирээд тэдний олонх нь эрт ургацын төмс хурааж улсад тушааж эхлэв.

Хар эргийн бригадаар орж комбайнч эмэгтэй Цэрэндуламтай уулзвал 4 жил дараалан төмсний комбайн жолоодож ургац хураалтын төлөвлөгөөг давуулж ирсэн ололтоо бататгаж энэ жилийн төлөвлөгөөгөө 120 хувь биелүүлэх үүрэг аваад ажиллаж байгаа аж.

Тэнд комбайнч Ж. Галбадрах, Ц. Санз, Бор нарын олон сайчууд Ц. Цэрэндуламтай уралдаантай ажиллаж эрт ургацаар 400 тонн төмс улсад тушаажээ.



Алтанбулаг сумын „Хөдөлмөр“ нэгдлийн „Алтан-Овоо“ бригадын хадланч Ч. Цэрэндорж олон жил дараалан хадлан хадаж, аймаг сумын аварга хадланч болсон юм.

Тэрээр энэ жилийн хадланд морин машинаар өвс хадах одор бүрийн төлөвлөгөөг 112—115 хувиар биелүүлж байна.

ЗУРАГ ДЭЭР:

Ч. Цэрэндорж хадлан-гийн талбайд

Д. ГУНГААБУУ-гийн авсан гэрэл зураг.

Отрын тарга-оны хүч

ОТРЫН БЭЛЧЭЭРТ

Лүн, Заамар, Баянцогтын САА-н малчид отор бэлчээрээр мал таргалуулах их аянд гараа сайтай байна.

Лүн сумын нам, захиргаа, олон нийтийн байгууллага отор нүүдэл хийх график төлөвлөгөө, нүүдэллэх зураг гаргаж оторт явах малчдыг гэр майхнаар хангаж, бүх бригадад отрын штаб байгуулжээ.

Одоо тус сумын хэмжээгээр адууны 3, тэмээний 1, үхрийн 8, хонины 28 суурийн 34000 гаруй мал Урангийн хөндий, Ногоон хоолой, Бор хоолой, Хөшигийн өвөр, Даажин зэрэг соргог сэрмүүн бэлчээрт оторт гарч тарга хүч авч байна.

Хоньчин Рэнцэндорж, Базар, Санжаа, Авидаа, Мягмар нар 10 гаруй удаа нүүж отор нүүдлийн ажилд хамт олноо хошуучилж явна.

Заамар сумын нам, захиргааны байгууллага Баян-Өнжүүл сумын хоньчин, БНМАУ-ын хөдөлмө-

рийн баатар Б. Ажваагийн туршлагаар отор нүүдэл хийж малдаа дээд зэргийн тарга хүч авахуулж байгаа гэсэн гэрчилгээг 20 шахам хүнд олгожээ.

Сумын хэмжээгээр одоогийн байдлаар 26 суурийн хонь оторт гараад байгаагийн гадна «Тосон» бригадын зөвлөл оторлолт, айлсалтыг буцад бригад малчдаас илүү сайн зохион байгуулжээ.

Тус сум отор нүүдлийг Тосонгийн бүрд, Хөндлөн ус, Хөөвөр, Хавцгайт гэсэн 4 чиглэлд гаргажээ. Бүрдний чиглэлд отор хийж яваа хоньчин, Ардын Их Хурлын депутат Л. Тогоо, аймгийн АХ-ын депутат П. Жавзанпхам нар хошуучилж байна.

Мөн Баянцогтын САА-н 21000 гаруй мал оторт гарч Туул голын зах, Хашаат, Хангайн урд захаар оторлож явна.

Тус сум малчдын ар гэрийнхэнийг Жирэмийн цагаан хөтөлд айлсалтаар буулгажээ.

Аюуш ахлагчтай адуучид, сумын 6 удаагийн аварга хоньчин Санжаа, хоньчин Юндэн нар хавраас хойш 10 гаруй удаа нутаг сэлэн нүүдлээд байна. Заамар, Баянцогтын САА-н нам, захиргаа, олон нийтийн байгууллагаас оторчид хадланчдын дунд үйлчлэн сурталчлах бригад гарган ажиллуулжээ. Уул бригад үсчин, лектор, кино концертын хэсгээр үйлчилж байна.

Энэ 3 сумын оторлолтын ажилд ийм амжилт, сайн эхлэлт байвч дутагдалтай зүйл бас байна.

Лүн сумын оторчид нүүх унаа хөсөг хүн хүч дутагдалтайн улмаас нэг малчин суурт 1000 гаруй мал оногдож байгаа нь оторлолтод бэрхшээл учруулж байна.

Мөн оторчдын ар гэрийг өргөн айлсалтанд буулгаагүй, оторчдыг эргэж тойрох урлагаар үйлчилэх тэдний дунд уралдаан өрнүүлж дүгнэх асуудал хийгдэхгүй байна. Тус сум отор сайн сайн зохион байгуулсан бригад тэргүүний оторчид, аймаг сумын аварга саальчдыг шалгаруулах уралдааны болзол зарласан боловч уг уралдааны явцыг өдий болтол нэг ч удаа дүгнээгүй байв.

Заамар сум нэгдлийн «Ундарган», «Ухаа» бригад «Тосон» бригадыг бодвол оторт нийт малчдыг гаргах, отор нүүдэл хийж буй малчдын ар гэрийнхнийг айлсуулах ажлыг хангалтгүй зохион байгуулж байна.

Иймд дээрх сумдын нам, захиргаа, олон нийтийн байгууллага отор нүүдэл хийж малдаа таргаа тэвээрэг авахуулах их ажилд олж буй амжилтаа улам бататгаж оршиж буй дутагдалдаа дүгнэлт хийж ажиллах явдал чухал байна.

Л. ГУНГААБУУ

Аймгийн хадлан тэжээл бэлтгэх ажлын явц

Аймгийн хэмжээгээр 8 дугаар сарын 21-ний байдлаар 36,3 мянган тонн өвс бэлтгэж 37,9 хувийн биелэлттэй байгаа нь өнгөрсөн оны энэ үеийнхээс 7,6 мянган тонн буюу 26,5 хувиар илүү байна.

Сумдын хадлангийн явцыг цуваагаар байр эзлүүлбэл:

сумд	хувь	байр
1. Жаргалант	62,4	1
2. Өндөрширээт	56,2	2
3. Баянцогт	54,3	3
4. Баян-Өнжүүл	51,3	4
5. Борнуур	50,3	5
6. Лүн	43,9	6
7. Батсүмбэр	41,4	7
8. Заамар	39,9	8
9. Баянцагаан	38,7	9
10. Угтаал	36,6	10
11. Мөнгөнморьт	36,3	11
12. Эрдэнэсант	36,0	12
13. Баян	32,2	13
14. Дэлгэрхаан	30,6	14
15. Эрдэнэсант ТАА	30,3	15
16. Бүрэн	28,2	16
17. Баянзүрх	26,1	17
18. Сэргэлэн	24,9	18
19. Эрдэнэ	22,5	19
20. Баянчандмань	17,8	20
21. Алтанбулаг	17,6	21
22. Архуст ТАА	16,4	22
23. Баяндэлгэр	13,3	23
24. Баянжаргалан	12,4	24

Хадлан тэжээл бэлтгэх ажлын явцыг дүгнэж үзэхэд аймгаас зарласан уралдааны болзолын хэмжээг нэг ч байгууллага хангаагүй байна.

Хадлан тэжээл бэлтгэх, ургац хурлах ажил эрхлэх аймгийн комисс

УГАЛЗАТ БРИГАДЫН ХАН

Эрдэнэсант сум нэгдлийн «Угалзат» бригадын хадланчдыг намын хэсгийн зохион байгууллага Лувсангомбо удирдан 7 дугаар сарын 23-нд Шар дэл гэдэг газар, морин машин 3, тармуур 1, хүн 11, морь 17, гэр 2-той гарсан байна.

Хадах өвс тачир сийрэгч гэсэн эд нар цагийг бүрэн ашиглан 1 га-гаас 2 центнер өвс авч одоо 220 тонн өвс хадаад байна.

Хадагч Батмөнх, Даваа нар өдрийн нормыг тогтмол биелүүлж байгаагаас гадна эд нар 5 эмнэг морь сургажээ.

Цаашаа яваад Дашгай гэдэг газар очиход тракторын дуу нүжигнэн энд тэндгүй боосон өвс ярайж хадлангийн талбайд Улаан баатар хотын 51 дүгээр дунд сургуулийн хөдөлмөр зуслангийн 34 хүүхэд 2 багийн хамт өвс цуглуулах хураах, ачих ажлыг сайн хийж байлаа.

Бригадын дарга Рагчаа-базартай уулзахад бид 511 тонн өвс хадаад байна. Техник саатахгүй бол 9 сарын 1-нд бригадын өвсний төлөвлөгөөг биелүүлнэ гэж ярих.

Ж. ЛХАМСҮРЭН

БАГШ НАРЫН БАГА ХУРАЛ

Саяхан хуралдсан аймгийн багш нарын ээлжит бага хуралд улсын багш нарын зөвлөлгөөн угтаж зохиож байгаа ажил хойшид тавих зорилтын тухай илтгэлийг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны Ардын боловсролын хэлтсийн дарга Т. Гаваа, «Сургалтын шинэ системээр хичээллэж 1, 2 дугаар ангийн сургалтын 2 жилийн дүн, хойшид тавих зорилтын тухай» илтгэлийг сургалт заах аргын кабинетын эрхлэгч Д. Будрагчаа нар тавьж хэлэлцүүлэв.

Илтгэлүүдтэй холбогдуулан Баянцогтын дунд

сургуулийн захирал Жамбаа, Баян сумын дунд сургуулийн багш Харганаа, Төвийн 10 жилийн дунд сургуулийн багш Цэвэгдорж, Жаргалантын дунд сургуулийн захирал Гончигсүрэн, аймгийн ХЗЭ-ийн хорооны хоёр дугаар нарийн бичгийн дарга Д. Хандсүрэн, Ургац нийгэмлэгийн дарга Даваа нарын 20 шахам хүн уг хэлж санал шүүмжлэл тавив. Бага хуралд аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга А. Давааням, Ардын боловсролын Яамны ажилтан Ч. Сувдаа нар оролцож үг хэлэв.

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧИЙГ ЗҮЙ ЗОХИСТОЙ АШИГЛАЙ

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 1960 оныхтой харьцуулахад 1972 онд 5,1 дахин, цахилгаан станцуудын хүчин чадал гурав дахин өсч аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин 14,7 хувь болсон байна.

Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн цахилгаан эрчим хүчийг хэрэглэгч үйлдвэр аж ахуй соёлын байгууллагууд айл, өрх нэг бүр зүй зохистойгоор зохих зориулалтын дагуу хэрэглэж арвиг гамтай зарцуулах ёстой.

Цахилгаан эрчим хүчийг зөв зохистой ашиглах талаар нам, засгаас байнгын арга хэмжээ авч байдгийн нэг илрэл нь 1973 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 47 дугаар тогтоолоор

батлагдсан цахилгаан эрчим хүч ашиглах дүрэм юм. Энэ дүрмийг биелүүлэх талаар үйлдвэр аж ахуй соёлын газрууд хангалтгүй мөрдөж байгаагаас цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжинд гэмтэл гарах явдал арилахгүй байна.

НААУ-ний газрын уурын зуухны цахилгаан хөдөлгүүрийг буруу суурилуулах, төмөр утсаар дарж боох зэргээр тогтоосноос хөдөлгүүр сууринаас хөдлөж ачаалал ихэдсэнээс шатах, дэд станцын гал хамгаалагч тасрах зэрэг гэмтэл 1974 оны 1 дүгээр улиралд олон удаа гарч байв.

Цахилгаан эрчим хүч нь үнэ хямдтай, ажиллахад хялбар бүтээгдэхүүн боловч буруу ашиглавал амь насанд ч аюул

хүргэж болзошгүй онцлог бүтээгдэхүүн гэдгийг цахилгаан эрчим хүч хэрэглэгч байгууллага, хүн бүр анхаарах хэрэгтэй юм. Цахилгаан тоног төхөөрөмж дээр ажилладаг ажилчин нэг бүрт хөдөлмөр хамгааллын зөвлөгөө өгөх, хамгаалагч багаж хувцасаар хангасан байх явдал байгууллагын үүрэг байх ёстой.

Нэгдэл дундын үйлдвэр, хотын худалдааны трестын гуанзны зарим төхөөрөмжүүд газардлага байхгүй ажиллаж байгаа нь хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагааны дүрмийг ноцтой зөрчиж байна.

Цахилгаан эрчим хүч ашиглах дүрэм «хангагч хэрэглэгч байгууллага нь өөрсдийн балансад бүрт-

гэлтэй цахилгаан шугам сүлжээ тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг өөрийн хүч хөрөнгөөр хийнэ» гэж заасан боловч хэрэглэгчид өөрсдийн цахилгаан төхөөрөмж урсралтанд засвар үйлчилгээг хийдэггүйгээс өрөө тасалгааны гэрэл унтрах, потрон залгуурууд гэмтэх, хөдөлгүүр шатах явдал байнга гарч байна.

Жил бүр өөрсдийн цахилгаан төхөөрөмж шугам сүлжээ угсралтанд засвар үйлчилгээ хийх график гарсан хангагч байгууллагаар засвар үйлчилгээг чанар сайтай хийж байвал гэмтэл гарах явдал бүрэн арилна гэдгийг албан байгууллагын удирдлагууд анхаарвал зохино.

Цахилгаан эрчим хүчнийг нууцаар хэрэглэх, хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнийхээ үнийг тө-

лөхгүй байх явдал айл өрхөд байсаар байна.

Соёлын ордны жүжигчин Жамъянзураач Ичинноров нарын зэрэг хэрэглэгчид цахилгаан эрчим хүчний үнийг 2—3 жил төлөөгүй байна.

Үйлдвэр албан байгууллагууд ажилчин албан хаагчдынхаа цахилгаан эрчим хүчний хэрэглээнд судалгаа гаргаж зөрчлийг засуулж байвал зохино.

Цахилгаан эрчим хүчийг хэрэглэгч үйлдвэр аж ахуй, соёлын байгууллага, хүн бүр цахилгаан эрчим хүчийг ашиглах дүрэм, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм заавруудтай танилцаж амьдрал ахуйдаа хэрэглэж байгаа цахилгаан төхөөрөмжийг зөв ашиглаж сурах нь чухал байна.

Ч. ШАРАВАТ

Үндэсний музей байгуулагдсаны 50 жилийн ойд

Зуунмод хотын төв дунд орших сүм оройт цагаан байшингийн хаалгаар орж гарах хүмүүсийн хөл ер тасрахгүй.

Тэндээс хоёр гурваар зорчих хүмүүсийн байдал сэтгэл их л өндөр бөгөөд шинэхэн тоглосон жүжиг кино үзсэн байдалтай.

Энэ ч аргагүй юм. Тэрхүү цагаан байшин бол аймгийн ОНС музей бөгөөд үндэсний музей байгуулагдсаны 50 жилийн ой угтаж тус музейнхэн үзмэрээ нэмж шинэ булан, танхим байгуулсан болохоор үзэгч олонд сонирхох юм юу эс мундах вэ.

Музейн хаалгаар оруул л шинэ сонин үзмэр нь нүднээ тусах бөгөөд музейн эрхлэгч Д.Шагдарсүрэн тайлбарлагчийнхаа хамт орж ирсэн хүмүүсийг эелдгээр урьж үзмэрүүдээ, хамт олныхоо ажлаасаа танилцуулсаар явна.

Тус музей Үндэсний музей байгуулагдсаны 50 жилийн ой угтаж бүх ард түмний социалист уралдаанд үзэгчид, орло-

гын төлөвлөгөөг биелүүлэх, үзмэрээ нэмэгдүүлэх, цуглуулга, судалгаа хийх зэрэг арав шахам зүйл дээр үүрэг авснаа амжилттай биелүүлж байна.

Аймгийнхаа хөгжлийг социалист бүтээн байгуулалтын түүхэн үе шатаар нь гэрэл зураг, баримт материалаар харуулах, хөдөлмөрийн алдартнуудын гэрэл зургаар булан гаргах, манай нам, төрийн нэрт зүтгэлтэн агсан Ж. Самбуу, ууган зо-

дарсүрэн гуайтай уулзаж их ойгоо угтан зохиож байгаа ажлаасаа ярьж өгчийг хүсэхэд тэрээр шинэ үзмэрээ нүднээс БНМАУ-ын Соёлын Яамнаас Үндэсний музей байгуулагдсаны 50 жилийн ой угтаж зарласан уралдааны болзлыг гарган өмнө дэлгээд:

—Бид энэ болзолд заасан үзүүлэлтүүдийг үндсэнд нь биелүүлээд 8 сарын 1-нд биелэлтийг нь гаргаж Соёлын яаманд

жилийн ой угтаж аймгийн ОНС музейд ямар хувь нэмэр оруулах вэ гэсэн хуудсаар хүмүүсээс санал авч ажилласны үрээр 100 гаруй үзмэр цуглуулж нийт үзмэрийн тоог 3000-д хүргэлээ.

Өөрийн музейн ажилд Говь-алтай, Баянхонгор аймгийн ОНС музейн ажлын туршлагаас нэвтрүүлж, ЗСБНХОУ-ын Курган мужийн музейтэй холбоо тогтоолоо гэв.

Тус музейн салбар, Зуун

лахаар ажилдаа ороод байна. Ер нь уулан музейн үзмэрүүдэд Шагдарсүрэн гуайн ур ухаан оролцоогүй зүйл ховорхон юм. Тэрээр үндэсний музей байгуулагдсаны 50 жилийн ойд зориулсан ОНС музей, түүний салбар уулын музейг тохижуулснаас гадна усан доторхи ургамал амьтны байдлыг үзүүлсэн панорам хийсэн нь музей үзэгчдийн сонирхлыг ихэд татаж байна.

Аймгийн ОНС музей түүний салбар байгалийн музейг энэ жил үзсэн түм гаруй үзэгчдийн мянга шахам нь гадаад, дотоодын зочид бөгөөд баярласан гялайсан сэтгэлийнхээ үгийг сэтгэгдлийн дэвтэрт нь үлдээсэн нь ч гэсэн тус музейн хамт олны ажлын ололтыг илтгэх нэгэн жишээ юм.

Ийнхүү аймгийн ОНС музейн танхимаар үзэгчдийн хөл үл тасран шинэ сонин үзмэрээ үзэгч олондоо тайлбарласаар музейнхэн завгүй байна.

Ш. ЦЭРЭНДОО

ХҮМҮҮСИЙН ХӨЛ ҮЛ ТАСРАХ ГАЗРААР

Сурвалжлага

хиолч Д. Нацагдорж нарын танхимыг шинэ үзмэрээр баяжуулан тохижуулж тэнд сурагчид, залуучуудыг пионер болон МХЗ-ийн гишүүд хүндэтгэлтэйгээр элсүүлж музейгээс зохиох ажлыг сайжруулснаар энэ оны орлого үзэгчдийн төлөвлөгөө 5 сарын өмнө 100,1-118,3 хувиар биелүүлэв.

Музейн эрхлэгч Д. Шаг

рапорталлаа.

Энэ болзлыг биелүүлэхийн тулд музейнхээ үзмэр бүрийг картжуулан, сан хөмрөгийн бүртгэлийг шинэчлэн цэгцэлж хадгалалт, хамгаалалтыг сайжруулахын эерэгтэй үзмэр цуглуулах хайгуул шинжилгээний ажлыг Жаргалант, Мөнгөнморьт сумдаар хийсэн ба Үндэсний музей байгуулагдсаны 50

модны аман дахь байгалийн музейгээр ороход зугаалагч үзэгчдэд зориулсан ширээ сандал хийж, усан оргилуур байгуулсан нь сэтгэлд нэн таатай агаад одоо 8 ханатай модон гэр барихаар зураг төслийг нь гаргаад байгаа аж.

Түүнчлэн байгалийн музейн үзмэрийг чулуулгийн төрлүүдээр баяжуу-



Заамар сумын нам, захиргаа, олон нийтийн байгууллагаас үйлчлэн сурталчлах бригад гаргаж отор нүүдлийн малчид хадланч тариаланчдын дунд үйлчилүүлэв.

ЗУРАГ ДЭЭР: Тус бригадынхан өргөн айлсалт дээр концерт тоглож байгаа нь.

Л. ГУНГААБУУ:гийн авсан гэрэл зураг.

НОГОО БРИГАДЫНХАН

Жаргалантын САА-н жимс жимсгэний талбайд машин тракторын дуу нүргэлнэ.

Бид энгүүлэн тарьсан жимс жимсгэний ургацыг сонирхон явтал 40 орчим насны эмэгтэй биднийг угтан ирж уулзав.

Энэ бол тус САА-н ууган жимсчин С. Дугармаа байлаа.

Тэрээр 1962 оноос энд жимс жимсгэний мод ургуулан ажиллаж эхэлсэн аж. Өнгөрсөн жил алимны нэг бутнаас 50 кг жимс авчээ.

Энэ жил ч ургац муугүй, амласан үүргээ биелүүлэх боломжтой, манай салаа 10-аас доошгүй тонн ургац авах бололцоо той гээд тэнд ажиллаж буй хүүхдүүдийг зааж:

—Манай салааны отгон жимсчин, илгээлтийн эзэн Я. Чимгээ, зэрлэг цэвэрлэж байгаа Д. Туяа, Л. Бямбадорж, Г. Цогзол

маа, Г. Дамдиндулам нарын 10 гаруй хүүхэд энэхүйн 10 жилийн дунд сургуулийн 8 дугаар ангийг төгсгөж илгээлтээр ирээд алим жимсний талбай хариуцан аваад ажиллаж байна.

Эдэнд манай ахмад жимсчин Д. Должинжав, Норжмоо, Гандиймаа нарын олон сайчуул багшил даг. Алимны 1 га талбайд 40 тонн орон нутгийн бордоо хийж, хог ургамлыг түүн, үндэсний шороог 2—3 удаа суллан, бороо хурын байдлыг тохируулан 5—6 удаа услаж, шинэ тэжээл багатай гэж үзсэн бутандаа химийн ба эрдэс бордоо хийдэг.

Ер нь тэгээд жимсчин хувийн уйгагүй ажиллагаа үр дүнд хүргэдгийг үргэлж зөвлөдөг гэлээ.

Ингэж тус САА-н жимсний салааныхан жимс жимсгэний арвин ургацаахаар шамдаж байна.

Бид тэндээсээ эрт ургацын ногоо хурааж байгаа улсын аварга ногоочин Д. Дарьсүрэн ахлагчтай салааныхан дээр очлоо.

Талбайд энгүүлэн хураасан манжинг хэдэн хүн цэвэрлэн шуудайлж байв.

Энд улсын аварга ногоочин Ш.Цэвээн, Б. Баасанхүү, Ц. Гүндсамба, Б. Бадамханд нар өдөр бүрийнхээ нормыг 120—135 хувь биелүүлж эрт ургацын ногоо улсад тушаах төлөвлөгөөгүлэмж давуулж байгаа аж.

Манжингийн талбайд улсын аварга ногоочин Ш. Цэвээн манжинг цэвэрлэж байв. Тэр 1 га-гаас манжин хураах төлөвлөгөөг өнгөрсөн жил 240 хувь биелүүлсэн амжилтаа бататган энэ жил ноднингоос дутуугүй амжилт гаргах зорилттой байна гэв. Манай салааныхан эрт ургац хураалтаар 50 тонн манжинг улсад тушаав гэж тасгийн дарга Ж. Чунагдорж ярилаа.

ДАРЦАГТ ТРАКТОРЧИН

Баргын хоолой өгсөн явхад уул талын хөсөн толгой шагдалан хадлан хадсан зурвас талбай хариуцан Улаан дарцаг хийсгэсэн «МТЗ-50» тракторын кабиннаас өндөр нуруутай 30 гаруй насны эр гарч ирсэнтэй уулзвал тракторчин Цэрэннадмид гэж өөрийгөө танилцуулав. Өнөө жил Баргын хоолойн ургацын унац сайн байна.

Би «МТЗ-50» трактораар өдөрт 50—70 га газар хадгаж га-гаас 7—8 центнер өвс авч байна.

«МТЗ-50» трактораар өдөр тутмынхаа нормыг 150—180 хувиар биелүүлж уралдаанд 3 удаа түрүүлж «социалист уралдаанд түрүүлэгч» гэдэг дарцаг хадгалж явна гэв.

Тракторчин Цэрэннадмид 1960 оноос хойш Өндөрширээт сумын «Хөгжил» нэгдэлд тракторчнаар ажилласан аж.

Машин техник шинэ байх тутам түүний бие ангиудын үрэлтээс жижиг хэсгүүд нь амархан элэгдэж эрэг боолтын бэхлэгээр нь хүртэл сулардаг тул заавал зүгшрүүлэлт хийж шалгадаг.

—Мөн тракторыг эхлээд хурдны араа тус бүрээр нь 30 орчим минут явуулж нийтдээ 20 гаруй цаг ажиллуулсны дараа хөдөлгүүр, явах анги, хурдны хайрцаг, хурд дамжуулах хэсгийн тосыг юулж шинэ тос хийнэ.

Тракторыг зүгширсний дараа талбайд ажиллуулахдаа хөдөлгүүрт өгөх ачааллыг бага багаар нэмж дасгах хэрэгтэй.

Тоос шороо их үед агаар шүүгчийн резин, хоолой түүний хөдөлгүүрт бэхлэгдсэн суурийн боолт суларснаас цэвэрлэгдээгүй агаар хөдөлгүүрт орвол муугаар нөлөөлдөг. Тракторт ус, тос, түлш шатахуун хийхдээ гадуур нь асгахгүй байвал тоос шороо, наалдах нь бага байдаг.

Ид ажлын үед түлшний савнаас хоног тутамд 3—4 литр тунадас авч, бүдүүн шүүрийн тунадасыг 24 хоног тутамд асгаж угаана.

Ингэж ажиллавал тракторын түлшний аппарат удаан хугацаанд эдлэгдэх төдийгүй моторын хүч тогтмол сайн байдаг.

Моторыг 240 цаг ажиллуулсны дараа тосыг нь солих буюу энэ хугацаанд нарийн шүүрийг 60 цаг тутамд нийтдээ 4 удаа угаах цэвэрлэх нь чухал. Ажилд гарах үедээ хөдөлгүүрийг тогтмол 70—80 градусын халуунтай байлгах нь дотоод шаталт сайн байх ач тустай.

Тракторт олон дахин ус сольж байх нь моторын ус хөргөгчийн ханыг хажуулж түүнээс болоод мотор хэтэрхий их халдаг гэж ярьв.

Цэрэннадмид бүх ард түмний социалист уралдааны жил 1973 онд «МТЗ-50» трактораар их засваргүйгээр 3000 гаруй км явж 850 тонн өвс хадгаж нэгдэлдээ 2000 гаруй төгрөгний ашиг оруулсан байна.

Өнөө жил 900 тонн өвс халдаж үүрэг аваад ажиллаж байна.

Н. НАНЖИД

ЦОЧИР ХҮЙТРЭЛТ ХЯРУУНААС ТАРИАГ ХАМГААЛЪЯ

Тэргүүний агрономчдын туршлага ажиглалтаас үзэхэд намар эрт таримал ургамлын цэцэглэлтээс үр тарианы сүүн болцын үе хүртлэх хугацаанд буюу 8 сарын 22-ноос 9 сарын 1-ний дотор тус аймгийн үр тариа, төмс, хүнсний ногооны гол талбайгаар 1-ээс 6 градус хүртэл гэнэт цочир хүйтрэлдэг байна. Тус аймгийн Угтаал, Жаргалант, Борнуурын САА сүүлийн жилүүдэд гэнэтийн хүйтрэлт хяруунаас хамгаалах пост группийг томилон талбайд утаа тавих, усалгаа хийх, ил гал түлэх зэрэг олон аргыг хэрэглэж байгаа нь зохих үр дүнгээ өгч байгаа юм.

Хяруунаас хамгаалах аргын дотроос эдийн засгийн хувьд хямд, үр ашиг

сайтай нь утаа тавих, усалгаатай нөхцөлд ургацыг услах явдал юм.

Угтаал, Жаргалант, Борнуур, Батсүмбэрийн САА, Эрдэнэсантын ТАА орон нутгийн нөөц бололцоо ашиглан сүрэл, урьд жилүүдийн үлдэгдэл хэрэгцээгүй өвс, үртэс, бууц зэргийг талбайн аль эрт хяруу унаж гэмтэл учруулдаг хэсэгт хоёр метрийн диаметртэй, 1,5 метр өндөр овоог 60—80-аар нэг талбайд байхаар хоорондын зайг тохируулан байрлуулж, мөн Угтаалын САА 2—3 эгнээ байрлуулан хэд хэдэн удаагийн хяруу гэнэтийн хүйтрэлтээс утаа тавьж хамгаалах бэлтгэл хийлээ.

Борнуур, Угтаалын САА хяруу хамгаалах овоонуудыг утаагийн нь талбайг дайрч өнгөрөө

хоёр байрлуулж аль болохоор удаан багаинулахын тулд шатах зүйлээ сайн нягтруулж үелүүлэн, овоонуудын доогуур мод шургуулан хөндийлж салхи агаар оруулах, нэг газраас нөгөөд шилжүүлэх зэргээр бэлтгэжээ.

Борнуурын САА намрын цочрол хүйтрэлтийн үед усалгаа хийснээр ургамлын орчны агаар хөрс чийгшүүлж хүйтрэлээс хамгаалах баттай арга хэрэглэж байна.

Талбайг услахаа суваг шуудуугаар услах, бороожуулагч машин ажиглуулах аргыг хослон хэрэглэн. Угтаалын САА-н Хар чулуутын тасгийнхан хяруу эрт унах талбайн зураглал гарган утаа тавих бэлтгэлийг хангаж гэнэтийн хүйтрэлтийн үед мэдээ дамжуу-

лан утаа тавих пост унаа мотоцикль, машин хийг томилон урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авчээ.

Гэтэл Батсүмбэр, Байнцогтын САА, Заамар, Энхтуул, Хөгжил зэрэг олонх нэгдэл гэнэт хүйтрэлт, хяруунаас үр тариа, төмс, хүнсний ногоог хамгаалах бэлтгэлийг ор нэрийн төдий хийж энэ талаар төлөвлөсөн тодорхой ажилгүй байна.

Батсүмбэрийн САА 500 шахам газрын төмсийг хамгаалах бэлтгэлгүй байснаас зургаан сарын хорин орчим соёлолтын үед нь хяруунд цохилснаас төмсний болц арав гаруй хоногоор хойшилж намрын хяруу хүйтрэлтэд нэрвэгдэж болзошгүй байхад хамгаалалтын бэлтгэл хийгээгүй байв.

Ер нь тус аймгийн үр тарианы голыг эзэлдэг САА, ТАА, нэгдлүүд гэнэтийн хүйтрэлт хяруунаас тариаг хамгаалах бэлтгэлийг талбайд бага зэрэг бууц, сүрэг овоолсноор санаа тайвширан, зохион байгуулалтыг муу хийж байгаа дутагдал байна.

Ийм ч учраас 8 сард Заамар сумын Заамар нэгдэл нилээд га газрын үр тариаг хяруунд цохилж ургац авах бололцоо алджээ. Энэ жил нийт тариалангийн талбайн ургац шингэн, зарим талбайн ургац аарцан боловсролтын үе дундаа орж байхад зарим нь сүүн бололтын үе, зарим нь цэцэглэлтийн үед байгаа учраас хяруу гэнэтийн хүйтрэлтээс хамгаалах арга технологийг сайжруулан тэнд ажиллагчдын хариуцлагыг өндөржүүлэх нь чухал юм.

О. СУМЬЯА

Мэргэжилтний зөвлөгөө

НОМБАЙНЫ ХАДАХ АППАРАТЫН ТОХИРУУЛГА

Хадах аппаратын хэрэгсэл хөшүүнүүд нэг хавтгай дээр оршихоор байх ба ингэснээр хэрэгсэл хошууны хоорондуур хутга чөлөөтэй хөдөлж хутга, хэрэгсэл хошуунаас үзүүр хэсгээр 0,5 мм, сүүл хэсгээрээ 1 мм зайтай байвал зохино.

Мөн хутга мэлхий даралт хоёрын хооронд 0,1—0,5 мм байх, үүнийг тохируулахад мэлхий дараасны бэхлэгээр чангалан тохируулна.

Хутганы хамгийн захын байрлалт хэрэгсэл хошууныг голд байх ёстой ба зөрүү нь 3 мм-ээс хэтэрч болохгүй. Энэ хэмжээг нээс хэтэрвэл шатууныг уртасгах богиносгох замаар тохируулна.

Энэ тохируулга алдагдсанаас болж хадалтын чанар муудах ба шатуунаа хугалдаг гэмтэй.

Гулгагч улыг тохируулах

Гулгагч улаар хадалтын өндөр намыг тохируулдаг. Гулгагч улын бариул дээрх хоёр нүхийг түүний хажуугийн гурван нүхийн аль нэгтэй нийлүүлж холбох замаар хадах өндрийг 100—180 мм хүртэл өөрчлөн тохируулж болно.

Гулгагч улын энэхүү тохируулга хэвийн хэмжээндээ байх эсэх нь хадагчийг тэнцвэртэй байлгах үүрэг бүхий нүршний тохируулгаас шууд хамаарна. Энэ нь газрын гүдэн хотгор донсолгооноос болж гулгагч ул дээр дарах хадах аппаратын даралтыг тогтмол 25—30 кг байлгах зорилготой юм. Үүнээс үндэслэж 30 кг дайтай дарахад хадуур өргөгдөж байхаар бодож нүршийг чангалж тохируулна.

Энэ тохируулгыг хийгээгүйгээс болж будааг хадах өндөр алдагдахаас гадна зарим газарт шороо түрж хэрэгсэл хошууны ир амархан эвдэрдэг явдал бий.

Хадагчийн шнекийн тохируулга Тарианы өтгөн шингэнээс хамааран шнекийн хамуур шүд хадагчийн ёроол хоёрын хоорондох зайг ихэсгэх юмуу багасгаж тохируулна.

Энэ тохируулгыг хийхдээ гар бариулын тусламжаар 6 мм—30 мм хүртэл ихэсгэж багасгана.

Мөн нэмэлт тохируулгаар 15—35 мм-ийн хооронд тохируулж болно.

Үүнд шнекийн голыг бэхэлсэн дөрвөлжин төмрийг гайхын тусламжаар дээшлүүлэх буюу доошлуулна.

Г. БЯМБАРЕНЧИН



Аймгийн хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний зөвлөл, ХЗЭ-ийн хорооны Д. Хандсүрэн ахлагчтай «Тойрон аялалынхан» сайхан Жанчивлин рашаан сувилал, Туяа нэгдлийн төвд ирж концерт тоглох. Дуучин Ичинхорлоо, Дуламсүрэн, Дэлэг, бүжигчин Чангалдулам, ерөөлч Санжидшарав, Жамъян, хөгжимчин Лувсанбидон, Намнангомбо нарын тоглолт үзэгчдээс өндөр үнэлэлт авав.

Д. ОТГОН

Эрдэнэ сумын бүх албан байгууллага хүмүүс малын тэжээл бэлтгэх ажилд

гарч сумын хэмжээгээр 1300-д тонн өвс бэлтгээд байна. «Эрдэнэ уул» бригадын Осоржам, Жамъян нарын суурийн хадланчид эхний 10 хоногт төлөвлөгөөгөө 109—110 хувь бие лүүлжээ. Нарстай бригадын хоньчин, намын гишүүн Х. Юндэндорж морин машинаар өвс хадаж, өдөр бүрийн нормоо 200 хувиар биелүүлэн 10 хоногт 56 тонн өвс хадаж сумаас зарласан уралдааны болзлыг хангав.

Жаргалантын САА-н Чойндондорж ахлагчтай хадлангийн механикжсан бригад 8500 тонн өвс хадаж бэлтгэхээр механикжсан 2 салааг зохион байгуулан гаргаж одоогийн байдлаар 5300 гаруй тонн өвс хадаж 4900 гаруй тонн

өвс боож нуруулдаад төлөвлөгөөнийхөө 61,3 хувийг биелүүлээд байна.

Энэ бригад хадах, боох, нуруулдах 7 хоногийн төлөвлөгөөг 137—163 хувиар биелүүлж трактор хадуурч, тармуурч боогчдын 80 гаруй хувь нь 7 хоногийн төлөвлөгөөг 37—69 хувиар давуулан биелүүлэв.

Ш. ЯДАМСҮРЭН

Баяннэжүүл сум 1974 онд малын тэжээлд зориулж 100000 зоодой бэлтгэхээс одоогийн байдлаар 93000 гаруйг бэлтгэсний дотор Хүний их эмчийн салбар, ясли, цэцэрлэг, зочид буудал зэрэг албан байгууллагууд зоодой бэлтгэх төлөвлөгөөг 100—104 хувиар биелүүлэв.

Ц. ЖАДАМБАА



Лүн сумын «Энхтүүл» нэгдлийн тракторч З. Лувсандарва трактор хадуураар өдөр бүрийн норм төлөвлөгөөноос 5—8 га-гийн өвс илүү хадаж хамт олноо хөшүүчилж байна.

Тэрээр хадуурын ирийг мохоохгүйн тулд өвсний гарц газрын өв сөвийг харж хадуураа тохируулан тавьж чаддаггаас техникийн элдэв саатай гаргадаггүй ажигладаг байна.

Мөн ажилд гарахын урьд орой нь техникийнхээ эрэг боолтыг сайтар шалган шатахууныг хүрэлцэх хэмжээгээр бэлтгэн нөөцлөж авдаг нь талбайд үл ялх саатай, зогсолт гарахгүй сайн талтай ажээ.

ЗУРАГ ДЭЭР: З. Лувсандарва хадуурын ир тохируулж байгаа нь.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧИЙГ Б.ЦЭРЭНДАШ

ЗАРЛАЛ

Лүн сумын харьяат Батзоригт овогтой Содномбалжид нь хүүхдийн тэтгэврийн 80998 номерын дэвтрээ, Заамар сумын харьяат Шагдар овогтой Эрдэнэчимэг, Бүрэн сумын харьяат Шагдарсүрэн овогтой Саранцэцэг нар иргэний 325609, 320976 тоот үнэмлэхээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.